

ЗАХИРАЛ БАТЛАВ М.АЮУШХОРЛОО

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН  
7 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛЛИЙН АНГИ ДЭВШИХ  
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ



2024.06.04 Хугацаа 60 минут А хувилбар Хэрлэн сум

Нийт оноо: 20 Анги: Сурагчийн нэр:

Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

**Салхитай танилцсан нь**

Салхийг би үзэн ядах болов. Хамгийн муухай юмны тоонд салхийг оруулав. Яагаад гэвэл байн байн салхи манай гэрийг авч явах гэж айлгадаг байлаа. Тэгж байтал их хэрэг гарав. Аав ээжийн түүж өвөлд бэлтгэсэн зургаан шуудай өвс байв. Түүнийг харж бай гэж аав надад захисан юм. Нэгэн өдөр гайхал салхи ирж зургаан шуудай өвсийг нэг нэгээр өнхрүүлэн тэртээ гүвээгээр давж одлоо. Салхи бид хоёр юутай их муудалцсан гэж санана. Салхийг биеэр олж хардаггүй дээ би ихээхэн хорсдог байв. Салхи их хүчтэй шүү. Түүнийг зогсоох юм байхгүй гэж аав ярьдаг байлаа. Тэгж салхи бид хоёр дайсан болоод хэдэн жил өнгөрөв. Би сургуульд орлоо. Аймгийн төв дээр ирж сурлаа.

-Ай мөн их салхитай газар шүү! гэж аймгийн төвийн тухай би сонслоо. Сургууль орсны маргааш өглөө салхи ирлээ. Аймгийн төвийн хамаг элс эрчлэн хуйлран хөх тэнгэрт гарч эргэн тойрон юу ч үзэгдэхгүй боллоо. Манай анги дөрвөн баганатай том бор гэрт байдаг байлаа. Хичээл дээр сууж байтал салхи эхэлсэн юм. Анхандаа өрх бүтээгдлээ. Дараа нь хэд хэдэн унь ойчив. Чойжилын толгой дээр цохижээ. Тэр уйлав. Хүүхдүүд айж тооно өөд ширтэнэ.

-Хүүхдүүд ээ, та нар чимээгүй сууцгааж бай. Би гараад гэрээ даруулаад ирье гэж багш хэлээд бостол хана, унь хажигнан шуугьж, анги маань нэг жайвийж, нэг шовойсноо нэвсгэнэх шиг болов. Бид бараг ухаан алджээ. Гэр ойчсон юмсанж. Дээрээс унь, эсгий дарж аваад хөдлөх аргагүй болгож хүүхдүүд шуугилдав. Салхи улам догширч байлаа. Олон багш нар хамсарч арайхийж биднийг салхины заналаас аварчээ. Түүнээс хойш долоон жилийн турш манай анги салхинд байн байн ойчсоор байв.

Ингэж би салхитай танилцав. Салхийг занатай байлаа. Гэтэл салхины тухай багш маань олон сонин юм яриу. Салхины хүчээр том тээрэм эргүүлдгийг мэдэв.

Салхи, салхи чи хүчтэй

Сүрэг үүлсийг туунам гэсэн шүлэг хожим нь цээжилж билээ.

/Л.Түдэв/

1. Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг бичнэ үү. (2 оноо)

2. Дараах энгийн өгүүлбэрүүдийг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр болгон бичээд, ямар аргаар холбон бичсэнээ тайлбарлаарай. (2 оноо)

*Хүүхдүүд айж тооно ширтэнэ. Салхи улам догширч байлаа.*

ЗНӨ:.....

Холбогдсон арга нь: .....

3. Доорх нийлмэл үгсээс зэрэгцсэн нийлмэл үг 2-ыг олж бичээрэй. (2 оноо)

*Алтан хараацай, эдийн засаг, эрх чөлөө, эрх танхи, элбэг дэлбэг, харж ханд, зүүн урд, бут ниргэ, бүтэн босго, гучин зургаа*

4. Зөв харгалзуулаарай. \2 оноо\

- |  |                       |
|--|-----------------------|
| 1. Тэмдэг нэрийн бууруулсан зэрэг бүтээх дагавар | а. –уул <sup>2</sup>  |
| 2. Дүрс дуурайх үг                               | б. –втар <sup>3</sup> |
| 3. Хам тооны нэр бүтээх дагавар                  | в. хор хор            |
| 4. Авиа дуурайх үг                               | г. хуга, нуга         |

5. Нөхцөлийг залгаж бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

санагдах+ыг.....

Холбогдох дүрэм .....

6. Уран зохиолын хичээлээр үзсэн зохиолоос нэгийг сонгон өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ 50-60 үгэнд багтаан бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....


.....

.....

.....

.....

7. Үндэсний бичгээс кириллд бичигт хөрвүүлээрэй.



.....

.....

.....

.....



ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН  
7 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ  
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.04 Хугацаа 60 минут **В хувилбар** Хэрлэн сум

Нийт оноо: 20 Анги: Сурагчийн нэр:

Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Чулуутай танилцсан нь

Чулууг би гартаа атгамагц таньдаг. Зун намрын зургаан сард хөл нүцгэн явдгаас чулууны авирыг хөлийн тавхай минь гараасаа илүү мэддэг байж дээ. Чулуу бид хоёрын нөхөрлөл улам гүнзгийрлээ. Нэгэн өдөр доод саахалтын зальт шар гэдэг том хүүхэд бидэн дээр ирж дундаа бариул мэт илэг оёсон урт сур үзүүлж

-Үүнийг та нар мэдэх үү? Дүүгүүр гэдэг юм. За харж бай гээд манай гэр дотроос Дэжидийн дээл болох гонзгой хүрэн чулууг авч нөгөө дүүгүүрийнхээ элгэн хавчаар дээр тохоод дээгүүрээ хэд эргүүлмэгц сурны нэг үзүүрийг тавьсанд жунгинасан сонин дуу гарч Дэжидийн дээл сэнс мэт эргэлдэн нисэж одов. Тэртээ урд энгэрт яс хэмлээд хэвтэж байсан нохойны зүг тэр сум нисэн одов. Төдхөн нөгөө нохойн хэмлэж байсан ясан дээр тасхийн буув. Нохой ганхийн гасалж сүүлээ хавчин ухаан зулаггүй зугтаж одов. Зальт шар инээж:

- Хо хо хо шар ах нь шарсан мах андахгүй гэж гайхуулснаа:

- Та нар балчир байна. Чулуугаар чинь ингэж тоглодоггүй юм. Чулуу чинь тоглоом биш зэвсэг. Чулуугаар дүүгүүрдэж туулай харайлгаж тоглодог юм.

Бид тэгээд чулуугаар зэвсэг хийх болов. Бид чулуугаар хонь, үхэр рүү шидэх болов. Зурам, хулгана руу илгээх болов. Хожим сургуульд ороод чулуун зэвсгийн үе гэж багшаас сонсов. Тэгээд чулуугаар би ч биш хүн төрөлхтөн өөрөө хорвоотой танилцсаныг ухааран мэдэж билээ. Бүр хожим чулуугаар хөшөө дурсгал босгодгийг мэдлээ.

Аяа чулуу чи ертөнцийн хөрсөнд ургасан хатуу цэцэг юм билээ.

/Л.Түдэв/

1. Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг бичнэ үү. (2 оноо)

.....  
.....

2. Дараах энгийн өгүүлбэрүүдийг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр болгон бичээд, ямар аргаар холбон бичсэнээ тайлбарлаарай. (2 оноо)

Чулуу бид хоёрын нөхөрлөл улам гүнзгийрлээ. Тэгээд чулуугаар зэвсэг хийх болов.

ЗНӨ:.....

Холбогдсон арга нь: .....

3. Доорх нийлмэл үгсээс зэрэгцсэн нийлмэл үг 2-ыг олж бичээрэй. (2 оноо)

Усан үзэм, эдийн засаг, эрх чөлөө, элбэг дэлбэг, харж ханд, бүтэн босго, гучин зургаа үр дүн, нялх балчир, ганц нэг, хонин гүрвэл

.....

4. Зөв харгалзуулаарай. (2 оноо)

- |  |                      |
|--|----------------------|
| 1. Тэмдэг нэрийн бууруулсан зэрэг бүтээх дагавар | а. дахь <sup>2</sup> |
| 2. Дүрс дуурайх үг                               | б. жир жир           |
| 3. Дэс тооны нэр бүтээх дагавар                  | в. -дуу <sup>2</sup> |
| 4. Авиа дуурайх үг                               | г. цөм               |

5. Нөхцөлийг залгаж бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.

салбар+ын.....

Холбогдох дүрэм .....

6. Уран зохиолын хичээлээр үзсэн зохиолоос нэгийг сонгон өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ 50-60 үгэнд багтаан бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

7. Үндэсний бичгээс кириллд бичигт хөрвүүлээрэй.

ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨ

.....

.....


.....

.....

.....

.....

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР



Д.БАЙГАЛМАА